



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШЛАЛ

2013 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус яамны харьяа “Эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох газар, хэлтэс, харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ерөнхий захирал нарт даалгасугай.
3. Эрүүл мэндийн байгууллагуудад Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах аргачлалыг боловсруулж, 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А. Эрдэнэтuya)-д даалгасугай.
5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 450 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Н. УДВАЛ

002902

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 11 сарын 26-ны өдрийн  
448 тоот тушаалын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ  
ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Энэхүү журмыг Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг/нийслэлийн Эрүүл мэндийн газар (ЭМГ) (цаашид “Эрүүл мэндийн байгууллага” гэх)-ын үйл ажиллагаа, Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын тушаал (цаашид “Холбогдох эрх зүйн акт” гэх)-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэхэд мөрднө.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар төрөөс баримтлах бодлогын үр дүн, үр нөлөөг сайжруулж, хариуцлагыг бэхжүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийг сайжруулахад оршино.

3. Аймаг, нийслэлийн ЭМГ нь холбогдох хууль, тогтоомж, энэхүү журмыг үндэслэн өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ХШҮ хийх журмыг батлан мөрднө.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээ**

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

5.1. Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх;

5.2. Явц, тайлан, дүгнэлт нь ил тод байх;

5.3. Үр дүнд чиглэсэн байх;

5.4. Тоо баримт, судалгаа, албан ёсны мэдээлэл зэрэг нотолгоонд тулгуурласан байх;

5.5. Хэрэглэгч, сонирхогч талуудын оролцоог хангасан байх.

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

5.1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон тусгайлсан гэсэн 2 төрлийн ХШҮ хийнэ.

5.2. Гүйцэтгэлийн ХШҮ нь дараах хүрээг хамарна. Үүнд:

5.2.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төлөөлөн хэрэгжүүлэгч (Аймаг, нийслэлийн Засаг дарга), төсвийн шууд захирагч (ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ерөнхий захирал)-тай байгуулсан үр дүngийн гэрээний хэрэгжилтийн байдал;

5.2.2. Эрүүл мэндийн сайдас ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ерөнхий захиралтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийн байдал;

5.2.3. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүн;

5.2.4. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт, үр дүн;

5.2.5. Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүн;

5.2.6. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт (энэхүү журмын Долоодугаар хавсралтад заасан байгууллага);

5.2.7. Хэрэглэгчийн үнэлгээ.

5.3. Тусгайлсан ХШҮ нь дараах хүрээг хамарна. Үүнд:

5.3.1. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ:

5.3.1.1. Эрүүл мэндийн хөтөлбөр, стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн;

5.3.1.2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн;

5.3.1.3. Эмнэлзүйн удирдамж, стандартын хэрэгжилтийн байдал;

5.3.1.4. Зайлшгүй шаардлагатай болон амин чухал эмийн хангамж, эмийн чанар, аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ;

5.3.1.5. Эмчилгээ, оношилгооны шинэ арга, дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлж, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр дүнг тооцсон байдал;

5.3.1.6. Эмнэлгээс шалтгаалах халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн;

5.3.1.7. Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой гомдлын шийдвэрлэлт;

5.3.1.8. Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээний талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

5.3.2. Байгууллагын удирдлага, хөгжил:

5.3.2.1. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн;

5.3.2.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн;

5.3.2.3. Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал, тухайн жилд зохион байгуулсан бэлэн байдлын сургалтын тоо;

5.3.2.4. Байгууллагын эрсдлийн удирдлага, эрсдэл бууруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал;

5.3.2.5. Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүн;

5.3.2.6. Тухайн байгууллагаас хэрэгжүүлж буй судалгааны хэрэгжилт, календарчилсан төлөвлөгөөний биелэлт;

5.3.2.7. Байгууллагын гадаад хамтын ажиллагаа, гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж буй төслийн үр дүн;

5.3.2.7. Байгууллагын хөгжил, соёлын талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

5.3.3. Хүний нөөцийн хөгжил:

5.3.3.1. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулах төлөвлөгөөний хэрэгжилт;

5.3.3.2. Төгсөлтийн дараах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн (дотоод, гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо, төгсөлтийн дараах сургалт явуулж буй мэргэжлийн чиглэл, суралцагсдын тоо г.м.);

5.3.3.3. Байгууллагын ажилтны нөөц бүрдүүлэлт, нөөцөөс авсан ажилтны тоо;

5.3.3.4. Ажлын байрны тодорхойлолтыг хэрэгжүүлсэн байдал;

5.3.3.5. Ажиллагсдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн;

5.3.3.6. Ажлын байран дээрх осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байдал;

5.3.3.7. Хүний нөөцийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

5.3.4. Санхүүгийн удирдлага:

5.3.4.1. Төсвийн гүйцэтгэл, өр, авлагын хэмжээ;

5.3.4.2. Төсөв, санхүүгийн ил тод байдал;

5.3.4.3. Албан бус төлбөрийг бууруулах арга хэмжээний үр дүн;

5.3.4.4. Аудит болон санхүүгийн эрх бүхий байгууллагаас тогтоосон акт, зөрчил, эргэн тайлагналт;

5.3.4.5. Нягтлан бодох бүртгэл, төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

5.3.5. Мэдээллийн удирдлага:

5.3.5.1. Статистик мэдээллийн үнэн бодит, шуурхай байдал;

5.3.5.2. Байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааны тогтмолжсон байдал;

5.3.5.3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд мэдээллийн технологийн зохицой хэрэглээг төлөвшүүлсэн байдал, үр дүн;

5.3.5.4. Эрүүл мэндийн мэдээлэл, мэдээллийн технологийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

**Гурав. Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг зохион байгуулах,  
мэдээлэх, тайлагнах үйл ажиллагаа**

6. Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Энэ үүргийг эрүүл мэндийн байгууллагад тэдгээрийн дарга, ерөнхий захирал нар хариуцна.

7. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох эрх зүйн актыг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

8. Эрүүл мэндийн байгууллага нь холбогдох эрх зүйн актыг хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан хугацаанд тайлагнаж, мэдээлэх үүрэгтэй.

9. Эрүүл мэндийн байгууллага нь холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн тайланг энэхүү журмын хоёрдугаар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гуравдугаар, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг дөрөвдүгээр, Үндэсний хөтөлбөр, стратеги, гадаадын зээл тусlamжаар хэрэгжиж буй төслийн тайланг тавдугаар хавсралтын дагуу тус тус гаргаж, энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан газарт хүргүүлнэ.

10. Эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн ХШҮ-ний тайлан нь энэхүү журмын 5.2-т заасан хавсралттай байна. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг энэхүү журмын зургаадугаар, Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг долоодугаар хавсралтын дагуу тус тус үнэн зөв гаргаж ирүүлнэ.

**Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

11. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ХШҮ-ний нэгж, Эрүүл мэндийн хөгжлийн төв хамтран хийнэ.

12. Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газар, хэлтэс шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

13. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг, удирдамжийг Эрүүл мэндийн сайд эсхүл яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, ажлын хэсгийн бүрэлдэхүүний 20 хүртэлх хувийг ХШҮ-ний чиглэлээр мэргэшсэн судлаачид, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж болно.

14. Зайлшгүй шаардлагаар Эрүүл мэндийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжаар бодлогын тодорхой чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж болно.

15. Ажлын хэсгийн ажиллах хэлбэр нь хурал байна. Хурлаас тэмдэглэл гарах бөгөөд уг тэмдэглэлд хуралд оролцогчид, гишүүдийн ирц, хэлэлцэх асуудлын агуулга, асуудлыг хэлэлцсэн явц болон хурлаас гарсан шийдвэрийг тус тус тусган, хуралд оролцсон гишүүдийн гарын үсгийг зурж баталгаажуулна.

16. Ажлын хэсгийн хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

264

17. Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

18. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан тоон болон тоогоор илэрхийлж болох зарим үзүүлэлтийг статистикийн болон тухайн үйл ажиллагааны хүрээний асуудлыг хариуцсан бусад байгууллагын судалгааны үзүүлэлт, тухайн жилд дээд шатны байгууллагаас газар дээр нь хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн зэрэгтэй харьцуулан нягталж үзнэ.

19. Байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ нь шалгуур бүрийн онооны нийлбэрийг нийт шалгуурын тоонд хувааж гаргасан дундаж оноогоор илэрхийлэгдэнэ. Үнэлгээний хувь болон оноог энэхүү журмын 24, 25-д заасны дагуу тодорхойлно.

20. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай тухайн онд байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ыг баримтлан дүгнэнэ.

21. Аймаг, нийслэлийн ЭМГ-ын даргын Үр дүнгийн гэрээг дүгнэхдээ аймаг, нийслэлийн Засаг даргаас ЭМГ-ын даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээг дүгнэсэн үнэлгээг үндэслэнэ.

22. Хэрэглэгчийн үнэлгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн үйлчлэх хүрээний хүн амын насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг эсхүүл эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргах бөгөөд уг үнэлгээг шууд хэрэглэнэ.

23. Хэрэглэгчийн үнэлгээг нийслэлд Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймагт Эрүүл мэндийн газар хийж гүйцэтгэнэ. Тус төв, газар нь энэхүү зорилгоор судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж судалгааг гүйцэтгүүлж болно.

24. Хүрэх түвшин нь тодорхойлогдсон шалгуурын гүйцэтгэлийн хувийг гаргахдаа зорилтын гүйцэтгэлийг (Г) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (3) харьцуулж хувиар илэрхийлнэ ( $\Gamma/3 \times 100$ ). Энэхүү хувийг 0.05-аар үржүүлж ( $\Gamma/3 \times 100 \times 0.05$ ) үнэлгээний оноог тодорхойлно.

25. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

- тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь;
- тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь);
- тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь);

- тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь);
- тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь);
- тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь);
- тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг “0” гэж үзнэ.

26. Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурьдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Үүнд:

Маш сайн	4.50-5.00 оноо
Сайн	4.00-4.49 оноо
Хангалттай	3.50-3.99 оноо
Дутагдалтай	3.00-3.49 оноо
Хангалтгүй	0.00-2.99 оноо

#### Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

27. Эрүүл мэндийн байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлнэ.

28. Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр тэргүүлсэн болон “Маш сайн” үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудад цалин нэмэх, гадаад улсад сургалт, танилцах аялалд хамруулах, салбарын шагналаар шагнах, төрийн одон, медальд нэр дэвшиүүлэх, удирдаж буй байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх эрх олгох зэргээр урамшуулна.

29. Үнэлгээний дүнгээр “Дутагдалтай”, “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

30. Шагнал, урамшуулалд зарцуулах хөрөнгийг ЭМЯ-ны төсөвт жил бүр тусгана.

Журмын нэгдүгээр хавсралт  
266

## ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

№	Тайлангийн төрөл	Тайлан хүлээн авах газар	Тайлан ирүүлэх хугацаа (сар, өдөр)	ЭМЯ-аас тайлагнах	
				газар	хугацаа
1	Холбогдох эрхзүйн актын биелэлт	ТЗУГ	01.05 06.20	ЗГХЭГ	01.15 07.10
2	Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн бодлогын биелэлт	ТЗУГ	12.20	ЭЗХЯ	02.01
3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	ТЗУГ	12.10 06.05	ЗГХЭГ	02.01 07.10
4	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	ТЗУГ	12.20 06.20	ЭЗХЯ	02.01 07.10
5	Үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилт	ХШУДАГ болон БХЗГ	12.20	ЗГХЭГ	04.01
6	Гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж буй төслийн хэрэгжилт	ХШУДАГ болон БТГ	12.20	ЗГХЭГ	04.01
7	Тухайн жилийн гүйцэтгэлийн ХШҮ-ний тайлан	ХШУДАГ	01.10	ЗГХЭГ	04.01
8	Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт	ТЗУГ	12.20	ЗГХЭГ	04.01

Журмын хоёрдугаар хавсралт  
267

ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ

№	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналтад байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө

Журмын гуравдугаар хавсралт  
268/43

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт		Тайлбар

Журмын дөрөвдүгээр хавсралт  
269

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

№	Зорилт	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Төсөв зарцуулалт	Хүрсэн түвшин, биелэлт	Тайлбар

270

Журмын тавдугаар хавсралт

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, СТРАТЕГИ, ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР  
ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛИЙН ТАЙЛАН**

<b>№</b>	<b>Хөтөлбөр/төслийн агуулга</b>	<b>Гүйцэтгэл</b>			
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Төсөл, хөтөлбөрийн зорилго			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв/зээл/ буцалтгүй тусlamж			
3.	Хэрэгжүүлэгч	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:			
4.	байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:			
5.	Төсөв (Нийт шаардагдах)				
Зардал	Үнд:	Tөсөв (он)	Гүйцэтгэл	Хувь	
	Багц 1				
	Багц 2 (г.м)				
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт: 1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ			
		1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл			
		2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл			
7.	Дүгнэлт	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал, дутагдалтай талуудыг энд бичнэ			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
		... %		... %	... %
					Зорилт 3 ... %

Журмын зургаадугаар хавсралт

**БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал</b>		
	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг нээлттэй, ил тод байрлуулсан эсэх;</li> <li>• Үйлчилгээг боловсронгуй болгох чиглэлээр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь;</li> <li>• Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх талаар зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь;</li> <li>• Байгууллагын дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдээс хэдэн санал авсан, үндэслэлтэй гэж үзээд төсөлд тусгасан саналын тоо;</li> <li>• Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг (дэвтэр) ажиллуулаад түүний мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь;</li> <li>• Хэдэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн.</li> </ul>	
<b>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</b>		
	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг ажилтнуудаас авч, түүний мөрөөр авсан арга хэмжээний тоо;</li> <li>• Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулах журмын дагуу шалгаруулсан ажилтны тоо;</li> <li>• Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх механизмыг бий болгож, үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд оруулсан өөрчлөлт, хэрэгжилтийн хувь;</li> <li>• Ажилтнуудыг сургах, орчин үеийн мэдээллээр хангах дэд бүтцийг бүрдүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь;</li> <li>• Нээлттэй зарласан сургалт, сонгон шалгаруулалтын тухай мэдээллийн тоо;</li> <li>• Эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг шийдэхэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа байдал, хамтын гэрээний биелэлтийн хувь.</li> </ul>	

*Гурав. Төсөөв, санхүүгийн ил тод байдал*

	<ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийг самбарт байрлуулсан эсэх;</li> <li>• Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан эсэх;</li> <li>• Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн эсэх;</li> <li>• Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авах, үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр авсан арга хэмжээ,, үйлчлүүлэгчдийн төлөх төлбөрийн хэмжээ, тарифыг цахим хуудсаар болон олон нийтэд нээлттэй мэдээлсэн эсэх;</li> <li>• Албан бус төлбөрийн талаар арга хэмжээ авсан эсэх;</li> <li>• Гадаадын зээл, тусlamж, хандивлагч олон улсын байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтын мэдээллийг цахим хуудсанд байрлуулсан эсэх.</li> </ul>	
--	--	--

*Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал*

	<ul style="list-style-type: none"> <li>• Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулсан эсэх;</li> <li>• Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулсан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар мэдээлэл гаргасан эсэх;</li> <li>• Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн эсэх;</li> <li>• Цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийн тоо.</li> </ul>	
--	---	--

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

## Нэг. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

№	Шалгуур үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлбар
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
5	Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь		
6	Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь		
7	2 настай хүүхдийн дархлаажуулалтын бүрэн хамрагдалтын эзлэх хувь		
8	Дутуу төрөлтийн түвшин (37 долоо хоногоос бага), 1000 амьд төрөлтөд		
9	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд		
10	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь		
11	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)		
12	2500 грамаас доош жинтэй төрсөн нярайн эзлэх хувь		

2749

13	1500-1800 грамм жинтэй нярайг амьдруулсан хувь		
14	Нялхын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)		
15	Тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)		
16	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
17	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
18	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насын 10 000 хүн амд)		
19	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
20	Цөслий чулуу, цөслий үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
21	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
22	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
23	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		
24	Өр, авлагын хэмжээ		

56  
275

**Хоёр. ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв,  
тусгай мэргэжлийн төв**

№	Шалгуур үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлбар
<b>2.1. Нийтлэг үзүүлэлт</b>			
1	Орны фонд ашиглалт		
2	Дундаж ор хоног		
3	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт (4-24 цагийн дотор)		
4	Өр, авлагын хэмжээ		
<b>2.2. Өвөрмөц үзүүлэлт</b>			
<b>2.2.1. Төв эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</b>			
5	Эрхтэн шилжүүлэн суулгасан байдал: <ul style="list-style-type: none"> <li>• Эрхтэн шилжүүлэн суулгасан тохиолдлын тоо</li> <li>• 1 жилээс дээш амьдарч буй хүний хувь</li> <li>• 3 жилээс дээш амьдарч буй хүний хувь</li> <li>• 5 жилээс дээш амьдарч буй хүний хувь</li> </ul>		
6	Гемодиализ эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа		
7	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
8	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
9	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насын 10 000 хүн амд)		
10	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		
11	Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насын 10 000 хүн амд)		

12	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)		
13	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)		
14	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		

## 2.2.2. Тусгай мэргэжлийн төв

## Хавдар судлалын үндэсний төв

15	Хорт хавдар анх оношлогдоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь (үндэсний хэмжээнд)		
16	Умайн хүзүүний хорт хавдар оношлогдоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь (үндэсний хэмжээнд)		
17	Хөхний хорт хавдар оношлогдоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь (үндэсний хэмжээнд)		
18	Элэгний хорт хавдар оношлогдоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь (үндэсний хэмжээнд)		
19	Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын тохиолдуудаас I, II үе шатанд оношлогдсон хавдрын эзлэх хувь (үндэсний хэмжээнд)		
20	Хими эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа		
21	Туяа эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа		
22	Хөнгөвчлөх эмчилгээний дундаж хугацаа		

## Халдварт өвчин судлалын үндэсний төв

23	Шинээр илэрсэн сурьеэгийн нийт		
----	--------------------------------	--	--



	тохиолдлоос ДОТС эмчилгээг бүрэн хийлгэсэн хувь		
24	ДОТС эмчилгээнд хамрагдагсдын эдгэрэлтийн хувь		
25	Олон эмэнд дасалтай сурьеэгийн эдгэрэлтийн хувь		
26	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		
27	Вирусын эсрэг эмчилгээнд хамруулсан архаг вируст гепатит өвчтэй эмчлүүлэгчийн тоо		
28	Бэлгийн замаар дамжих халдварын хавьтал илрүүлэлтийн коэффициент		
29	Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо (үндэсний хэмжээнд)		
30	Эмчилгээ шаардлагатай ХДХВ-ийн халдвартай хүмүүсээс ретровирусын эсрэг эмчилгээний хамрагдалтын хувь (үндэсний хэмжээнд)		

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв**

31	Дутуу төрөлтийн түвшин (37 долоо хоногоос бага), 1000 амьд төрөлтөд		
32	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд		
33	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь		
34	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд) – төвийн хэмжээнд		
35	2500 грамаас доош жинтэй төрсөн нярайн эзлэх хувь		
36	1500-1800 грамм жинтэй няraig амьдруулсан хувь		
37	500-1500 грамм жинтэй няraig амьдруулсан хувь		




38	Төрсний дараах эхний 5 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь		
39	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) - төвийн хэмжээнд		
40	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) - төвийн хэмжээнд		
41	Цусны хорт хавдар анх оношлогдсоноос хойш 10-аас дээш жил амьдарсан хүүхдийн эзлэх хувь		
42	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажгийн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		
43	Ушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		
44	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		
45	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		
46	Цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)		
47	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		

#### Арьсны өвчин судлалын үндэсний төв

48	Хяналтанд байгаа арьсны архаг, удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ шаарддаг өвчний намжмал үеийн дундаж хугацаа		
49	Арьсны хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)		

179<sup>5</sup>

50	Арьсны эдийн шинжилгээгээр оношийн баталгаажилтын хувь		
51	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		
<b>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв</b>			
52	Шинээр оношлогдсон өвчтөнг идэвхитэй хяналтанд авсан хувь		
53	Сэтгэцийн эмгэгтэй нийт өвчтөнүүдээс нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан хувь		
54	Архинаас гарах эмчилгээнд хамрагдсан хүний тоо		
55	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		
<b>Гэмтэл согог судлалын үндэсний төв</b>			
56	Осол, гэмтлээс шалтгаалсан өвчлөл (10 000 хүн амд) - үндэсний хэмжээнд		
57	Осол, гэмтлээс шалтгаалсан нас барагт (100 000 хүн амд) - үндэсний хэмжээнд		
58	Түнхний үе солих мэс заслын тоо		
59	Өвдөгний үе солих мэс заслын тоо		
60	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		
<b>Цус сэлбэлт судлалын үндэсний төв</b>			
61	Нийт доноруудад идэвхтэн доноруудын эзлэх хувь		

280

5.

62	Тухайн жилд шинээр бүртгэгдсэн донорын тоо	
63	Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоо хэмжээний өсөлт	
64	Цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлтийн хувь	

**Эмгэг судлалын үндэсний төв**

65	Задлан шинжилгээний хувь (үндэсний хэмжээнд)	
66	Үндсэн оношийн зөрүүний хувь (үндэсний хэмжээнд)	
67	Хүндрэлийн зөрүүний хувь (үндэсний хэмжээнд)	
68	Нийт нас баралтад эмнэлзүй эмгэг судлалын зөвлөгөөний эзлэх хувь	

ooo OOO ooo